


3.1. Эрхлэх асуудлын хүрээн дэхь төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

№	Агентлагууд	Ерөнхий үнэлгээ	
		Хувь	Оноо
Тэргүүн шадар сайдтай			
1	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс	92	4.6
Шадар сайдтай		97	4.8
1	Мэргэжлийн хяналтын газар	100	5
2	Онцгой байдлын хэлтэс	100	5
1	Хүүхдийн төлөө хэлтэс	95	4.7
4	Бүс нутгийн хөгжлийн асуудал	95	4.7
5	ХДХВ	95	4.7
Хууль зүй, дотоод хэргийн сайдтай			
1	Цагдаагийн газар	96.2	4.8
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай			
1	Байгаль орчин аялал, жуулчлалын газар	95.6	4.8
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай		94.3	4.7
1	Тээвэр авто замын газар	95.8	4.8
2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	92.8	4.6
Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдтай			
1	Боловсрол, соёлын газар	96.4	4.8
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай			
1	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс	94.5	4.7
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд			
1	Хүнс хөдөө аж ахуй, жижиг дугнд үйлдвэрийн газар	86.2	4.3
Эрүүл мэндийн сайд			
1	Эрүүл мэндийн газар	90	4.5
Батлан хамгаалахын сайд			
1	Цэргийн штаб	75	3.7
Эрдэс баялаг, эрчим хүчний сайдтай		92	4.6
Статистикийн хороо			
1	Статистикийн хэлтэс	100	5
Нийт		92.4	4.6



Эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт салбар тус бүрээр 75-100 хувийн биелэлттэй, “А”, “В” үнэлгээтэй, аймгийн дунджаар 92.4 хувийн биелэлттэй, 4.6 оноотой “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан аймгийн Цэргийн штабт Сургалт, иргэний хамгаалалтын асуудал хариуцсан ажилтныг

ажиллуулана гэж заагдсан заалт биелээгүйгээс 75 хувьтай “С” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт тухайн ажилтныг ажиллуулах орон тоо, цалингийн сан байхгүйгээс уг орон тооны ажилтныг ажиллуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг гаргахдаа бодитой тооцоогүй, Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу заалт бүрийн биелэлтийн хувийг гаргаагүй, бодит үр дүнг биш үйл ажиллагааг тоочиж бичсэн дутагдал байна.

Аймгийн Засаг дарга нь 2010 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол улсын хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1-д заасны дагуу харъяалах дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч нартай бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан ба эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт аймгийн дунджаар 92.4 хувийн биелэлттэй, 4.6 оноотой “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Гэрээний биелэлтийн хувь, үнэлгээг салбар тус бүрээр товч танилцуулъя.

Нэг: Тэргүүн шадар сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Аймгийн хэмжээнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд 4 бүтээгдэхүүний ангид 11 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэх гэрээ байгуулж, гэрээ 92 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Хоёр: Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Аймгийн Засаг дарга нь Монгол улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу аймгийн хэмжээнд Мэргэжлийн хяналтыг бэхжүүлэх, Онцгой байдлын цаг үеийн бэлэн байдлыг хангах, Хүүхдийн төлөөх төрийн бодлогуудыг хэрэгжүүлэх, Бүсчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил хамгааллыг сайжруулах, оролцоог дэмжих, гамшгаас сэргийлэх, хор нөлөөг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдвэрлэл үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлэх зэрэг бодлого зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь ерөнхий удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар шуурхай хангаж ажиллан гэрээ 97 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Шадар сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг салбар тус бүрээр харуулбал:

2.1. Мэргэжлийн хяналтыг бэхжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр:

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны чиглэлээр 6 стратегийн зорилтыг хангахад чиглэсэн 5 бүтээгдэхүүний ерөнхий ангид 23 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээ 100 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2.2. Онцгой байдлын цаг үеийн бэлэн байдлыг хангах асуудлаар:

Гамшгаас хамгаалах арга хэмжээний чиглэлээр 2 стратегийн зорилтын хүрээнд 4 бүтээгдэхүүний ангид 6 ажил үйлчилгээ, явуулах гэрээг байгуулж, гэрээ 100 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2.3. Хүүхдийн төлөө төрийн бодлогуудыг хэрэгжүүлэх асуудлаар:

Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийн хэрэгжилтийг хангах стратегийн зорилтын хүрээнд 4 бүтээгдэхүүний ангид 10 төрлийн ажил үйлчилгээг нийлүүлэхээр гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, гэрээ 95 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2.4. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар:

Бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад чиглэсэн стратеги зорилтын хүрээнд 3 бүтээгдэхүүний ангид нийт 9 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээ 95 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2.5. ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх асуудлаар:

ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх зорилтын хүрээнд 3 бүтээгдэхүүний ангид нийт 11 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүхээр гэрээ байгуулан ажиллаж гэрээ 95 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Гурав: Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалтын асуудлаар 8 стратеги зорилтын хүрээнд 4 бүтээгдэхүүний ангид нийт 33 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэхээр бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ байгуулж, гэрээ 96.2 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Дөрөв: Байгаль орчны сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Орон нутгийн ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, ус цаг уур орчны шинжилгээ, байгаль орчин

аялал жуулчлалын чиглэлээр 4 стратеги зорилтын хүрээнд, 4 бүтээгдэхүүний ангид нийт 17 бүтээгдэхүүн ажил үйлчилгээг нийлүүлэхээр бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ байгуулж, гэрээ 95.6 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тав: Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Зам тээвэр, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр нийт 8 стратегийн зорилтын хүрээнд 31 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж гэрээ салбарын дунджаар 94.3 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг салбар тус бүрээр харуулбал:

5.1.Зам тээврийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр 4 стратегийн зорилтын хүрээнд 9 бүтээгдэхүүн ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж гэрээ 95,8 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй байна.

5.2.Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын чиглэлээр 4 стратегийн зорилтын хүрээнд 22 бүтээгдэхүүн ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж гэрээ 92.8 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй байна.

Зургаа : БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай боловсрол, соёл урлагийн чиглэлээр 2 стратеги зорилтын хүрээнд 19 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулж гэрээ 96.4 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Долоо: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай 5 бүтээгдэхүүний ангид 40 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээ 94.5 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Найм: ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

ХХААХҮ-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг дарга 6 төрлийн бүтээгдэхүүний ангид 49 нэрийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээ 86.2 хувьтай “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Ес: Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Эрүүл мэндийн салбарын чиглэлээр 7 стратегийн зорилтын хүрээнд 8 бүтээгдэхүүний ангид 39 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх бүтээгдэхүүн

нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ байгуулж, гэрээ 90 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Арав: Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Батлан хамгаалах салбарын чиглэлээр 5 бүтээгдэхүүний ангид, 14 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээ байгуулж ажиллан, гэрээ 75 хувийн биелэлттэй “С” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Арван нэг: Эрдэс баялаг, эрчим хүчний сайдтай байгуулсан гэрээний биелэлт

Аймгийн эрчим хүч, цахилгаанжуулалт, дулаан хангамжийн асуудлаар гэрээ байгуулж ажиллан гэрээ 92 хувийн биелэлттэй, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Арван хоёр: Үндэсний статистикийн хорооны даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Улсын стандартартад нийцсэн статистикийн мэдээллийг гаргах, улсын чанартай тооллогуудыг зохион байгуулах стратеги зорилтын хүрээнд 4 бүтээгдэхүүний ангид 16 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээ 100 хувийн биелэлттэй “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ